



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 17 сарын 30 өдөр

Дугаар 51

Мандалговь

**Хөрөнгө акталж худалдах тухай**

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт , 77.3 дахь хэсэг , аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн 2.1.7 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн 5.8 а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг:** Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2010 онд ашиглалтанд орсон 18,000,000 /Арван найман сая/ төгрөгний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ДУА 53-90 улсын дугаартай УАЗ-315122 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

**Хоёр:** Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3,000,000 /Гурван сая / төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар/С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

**Гурав:** Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дарга /Б.Нанжид/-д даалгасугай.

**Дөрөв:** Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР